



Сайдын 2006 оны 10 сарын 6-ны тушаалаар хүчингүй

МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2006 оны 10 сарын 6 өдөр

Дүгээр 342

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай


Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын 2005 оны 3 дугаар сарын 3-ны өдрийн 52 дугаар тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт суралцах хүмүүсийг сонгон шалгаруулах журам", Өндөр хөгжилтэй орны их сургуулийн магистрантур, докторантурт Сургалтын төрийн сангийн зээлээр өөрийн захиалгаар хүн суралцуулах эрх бүхий байгууллагын саналыг үндэслэн ТУШААХ нь:

1. 2006-2007 оны хичээлийн жилээс Шарав овогтой Лувсмааг АНУ-ын Флорида дахь Метрополитан /Florida Metropolitan University/ дээд сургуулийн дэргэдэх англи хэлний эрчимжүүлсэн хөтөлбөр, магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 2 жилийн хугацаагаар суралцуулсугай.

2. Шарав овогтой Лувсмаагийн сургалтын төлбөрийг хэлний бэлтгэл дуусан тус сургуулийн үндсэн ангид суралцах үеэс эхлэн олгохыг Сургалтын төрийн сангийн захирал П.Лхагвасүрэнд даалгасугай.

3. Ш.Лувсмаагийн магистрын судалгааны ажлын чиглэлийг нарийвчлан тохирч, гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг Санхүү, эдийн засгийн газрын дарга Ц.Даваасүрэн, Төрийн захиргааны удирдлагын газрын дарга Л.Цэдэвсүрэн нарт тус тус үүрэг болгосугай.

4. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох сургуулийн нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /Д.Лхагвасүрэн/-д, энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Мэргэжлийн боловсролын газар /Р.Бат-Эрдэнэ/-т тус тус даалгасугай.



[Handwritten signature]

Ө.ЭНХТҮВШИН